



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2019.02.12 № 09

Асуулга тавих тухай

Эрдэс баялгийн салбар Монгол Улсын эдийн засгийн гол тулгуур билээ. Тэр дундаа нүүрс, зэс зэрэг ашигт малтмал экспортын гол орлогыг бүрдүүлж байна.

Өнгөрөгч 2018 онд экспорт өмнөх оноос 811,2 сая ам.доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний экспорт 1,1 тэрбум ам.доллар болж өссөн нь голлох нөлөө үзүүлжээ.

Тэр дундаа манай улсын баялгийн үүц болсон Тавантолгойн ордод “Эрдэнэс-Тавантолгой” ХК амжилттай үйл ажиллагаа явуулж 2010 оноос хойш үүссэн гадаад, дотоод өр төлбөр болох 681 сая ам.долларын өрөө бүрэн төлж барагдуулаад байна.

Өнгөрөгч 2018 онд тус компанийн борлуулалтын орлого 1,99 их наяд төгрөг болж нэмэгдэн улсын төсөвт 510 тэрбум төгрөг төвлөрүүлж, 720 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. Үүнтэй холбогдуулан иргэдийн 1072 хувьцааг амь оруулах, ногдол ашиг хуваарилах, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн цэвэр ашгийг төмөр зам, цахилгаан станц зэрэг томоохон бүтээн байгуулалтад зарцуулах талаар иргэдээс олон төрлийн санал, санаачилга гарах боллоо.

Иймд Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасны дагуу УИХ-ын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Танд хандан тавьж байна. Үүнд:


1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3-т заасан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг хөрөнгийн зах зээлд бүртгүүлэх, арилжих, эргэлтэд оруулах замаар иргэдэд эзэмшүүлсэн 1072 хувьцааг үнэ цэнэтэй болгоно” гэсэн зорилтын хүрээнд ямар ажил хийхээр төлөвлөж буй талаар;
2. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн цэвэр ашиг болох 720 тэрбум төгрөгөөс хэдий хэмжээний ногдол ашиг иргэдэд олгох талаар;
3. Нүүрс тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, экспортын орлогыг илүү өсгөхөд чухал ач холбогдолтой шинэ төмөр замыг хэзээ, ямар чиглэлд, хэрхэн барих тухайд Засгийн газар ямар бодлого боловсруулж байгаа талаар;
4. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжих зорилтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар;

5. Монгол Улсын эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг бүрэн хангах шинэ эх үүсвэрийг барих, Өмнөд говийн бүс нутгийн уул уурхайн цахилгааны хэрэглээг хангах, Тавантолгойн уурхайн нүүрсээр ажиллах цахилгаан станцыг барих асуудлуудыг хэрхэн шийдвэрлэж буй талаар;
6. Уул уурхайгаас, тэр дундаа "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн олсон цэвэр орлогоос агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр шийдвэртэй арга хэмжээ авахад зарцуулах боломж бий эсэх талаар тодорхой хариултыг боловсруулж ирүүлнэ үү.

Энэхүү асуулгын хариуг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



С.БЯМБАЦОГТ